

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт орших Арьсны өвчин судлалын үндэсний төв -ийн "Арьсны өвчин судлалын үндэсний төв" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг БОНХС-ын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчны мэргэжлийн байгууллага "Сайхан Ариун Дэлхий" ХХК гүйцэтгэлээ. Энэхүү төсөл нь Монгол Улсын хууль, дүрэм, журмын хүрээнд Монгол улсын нутаг дэвсгэрт тархсан хөрсний шинж чанарт, төлөв байдалд, бохирдолд үнэлгээ, дүгнэлт өгөх зорилготой юм.

1. Төсөл хэрэгжүүлэгч Арьс харшлын эмнэлэг хотын төвийн суурьшлын бүсэд ордог. Иймээс хөрс, ургамлан нөмрөг талхлагдаж анхы төлөв байдлаа алдсан. Байгаль орчинд учруулах боломжит хохиролын үнэлгээг БОАЖС-ын 2010 оны 156 тоот аргачлалаар тооцоход 233,4 сая төгрөг гарч байгаа бөгөөд өөрийн үйл ажиллагаа явуулж буй талбайдаа газрын чанарын хянан баталгаа хийлгэх, байгаль орчны үнэлгээ хийлгэж үнэлгээгээр батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэж ажиллах шаардлагатай. Ус ашигласны төлбөрийг усны тоолуурын заалтыг үндэслэн төлнө.
2. Арьсны өвчин судлалын үндэсний төв төсөл нь технологийн горим мөрдлөг болгон ажилласан нөхцөлд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай байна.
3. Арьсны өвчин судлалын үндэсний төв Цэцүүх, Сетунари, Пролианс, Монфатрейд, Мөнхийн тун, Грийн химистри зэрэг ХХК-даас химийн бодисыг худалдан авч ашигладаг. Иймээс байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, БОМТ-нд тусгагдсан шаардлагуудыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай. Химийн урвалж бодистой ажилладагтай холбоотой ажилтан ажиллагсдыг мэргэжлээс шалтгаалан өвчнөөс сэргийлэн эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах шаардлагатай.
4. Эмнэлгийн хог хаягдлыг Элемент ХХК-тай хийсэн гэрээний дагуу, энгийн хог хаягдлыг дүүргийн ТҮК-тай хийсэн гэрээний дагуу зайлуудаг байна. Хог хаягдлын асуудлыг анхаарч ажиллах шаардлагатай. Орчны агаарын эрүүл ахуй болон агаар орчны бохирдлын шинжилгээг хянаж байх шаардлагатай.
5. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны аудитыг 2 жил дутам хийлгэх ишаардлагатай.
6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр шинэчлэн боловсруулж БОАЖЯ-аар батлуулан ажилласан нөхцөлд энэхүү төслийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.